



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2 нэрийн нийт 348,351,200.00 (гурван зуун дөчин найман сая гурван зуун тавин нэгэн мянга хоёр зуун) төгрөгийн балансын үнэ, 38,612,600.01 (гучин найман сая зургаан зуун арван хоёр мянга зургаан зуун төгрөг нэг мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж нарт дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг
 2022 оны 05 дугаар сарын 14 -Ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт



Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
 Боловсрол, шинжлэх ухааны яаманд балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ (төгрөг)	Нийт хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	МБС салбарын Мэдээлэлтийн нэгдсэн систем	2021.12.01	1	328,351,200.00	328,351,200.00	27,362,600.01	300,988,599.99
2	Сервер дата төв	2019.12.01	1	20,000,000.00	20,000,000.00	11,250,000.00	8,750,000.00
	Нийт дүн		2		348,351,200.00 (гурван зуун дөчин найман сая гурван зуун тавин нэгэн мянга хоёр зуун)	38,612,600.01 (гучин найман сая зургаан зуун арван хоёр мянга зургаан зуун төгрөг нэг мөнгө)	309,738,599.99 (гурван зуун есөн сая долоон зуун гучин найман мянга таван зуун ерэн есөн төгрөг ерэн есөн мөнгө)